

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛЫГ СЭРГЭЭН
ТУНХАГЛАСНЫ ТҮҮХЭН АЧ ХОЛБОГДОЛ
(Монголд манжийн ноёрхлыг түлхэн унагасны 70 жилийн ойд)****Ш. Сандаг**

Түүхийн ухааны доктор

1981 оны арван хоёрдугаар сарын 1 бол монголын ард түмний 1911-1912 оны эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнолын төлөө өргөн тэмцлийн үр дүнд Монгол манжийн колоничлолын дэглэмийг түлхэн унагаж түүний үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг сэргээн босгосны 70 жилийн ойн тэмдэглэлт өдөр мөн.

Энэхүү тэмцэл нь монголын ард түмэн эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг байлдан олоход хэзээ ямагт зориг төгөлдөр байсныг харуулаад зогсоогүй, мөн Оросын 1905-1907 оны анхны хувьсгал нийт Дорно дахины ард түмэн, түүний дотор Монгол, Хятад, Солонгос, Вьетнамыг олон зуун жилийн харанхуй балай амьдралын нойрноос сэрээж улс төрийн тэмцэлд уриалан дуудсаныг нотолсон байна.

В.И.Ленин сод мэргэн онолч, тууштай интернационалч, холыг харагч хувьсгалчийн хувьд үгээгүй дарлагдсан ард түмний эрх чөлөөний хөдөлгөөн ба хувьсгалт тэмцлийн зайлшгүй ялах тавилантайд гүнээ итгэж, феодалын хамжлагат ёс нь хүй нэгдлийн харилцааны үлдэгдэлтэй хутгалдан хоцорсон Ази мэт ийм өргөн уудам эх газар улс төрийн тэмцэлд босох тухай урьдчилан харж билээ. В.И.Ленин «Ази сэргэсэн нь» өгүүлэлдээ бичсэн нь: «Дэлхийн капитализм 1905 оны Оросын хөдөлгөөн хоёр нь Азийг бүрмөсөн сэрээв. Дундад зууны зогсонги байдалд зэрлэгшин хоцрогдсон түм түмэн сая хүн ам шинэ амьдрал, хүний хамгийн наад захын эрх, ардчилалын төлөө тэмцэлд босов»¹ гэжээ.

ЗХУКН-ын Төв Хороо «1905-1907 оны хувьсгалын 70 жилийн ойн» тухай тогтоолдоо: «Энэ бол империализмын үеийн анхны ардын хувьсгал байсан бөгөөд хаант ёс, помещик, капиталистуудын ноёрхолд хүчтэй цохилт өгч ангийн тэмцлийн түүхэнд шинэ хуудас нээсэн билээ» гэж заасан байна.²

Хаант ёсыг эсэргүүцсэн Оросын анхны хувьсгал Монголын хувь заяанд шууд ба шууд бусаар нөлөө үзүүлсэн байна. Монгол орон Оростой айл хөрш тул тэнд болсон аливаа үйл явдал, тэгэх тусмаа Оросын анхны хувьсгал мэт ийм том хөдөлгөөн аль нэг шугамаар шууд нөлөөлсөн юм. Үүний зэрэгцээ энэхүү хувьсгал нийт Дорно дахины улс төрийн ухамсрыг сэргээн хувьсгалжуулж Дорно дахины бүх орнуудад, тухайлбал, Манжийн эзэнт гүрний дотор эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөн хүчтэй өрнүүлснээр тус гүрний зах хязгаар байсан Монголд колоничлолын эсрэг хөдөлгөөн өргөжин гүнзгийрэхэд дөхөм үзүүлсэн гэж хэлж болно. Энэ бүхэн бол Монголын ард түмэн харийн колонийн

¹В. И. Ленин. Зохиолын 19 дүгээр боть, 1966. 72 дугаар тал,

²«Правда», 19-75. 1. 9

дарлалыг эсэргүүцсэн эрэлхэг тэмцэлд босоход гадаад аятай сайхан нөхцөл бүрэлдүүлсэн ажээ.

Монголын 1911-1912 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөн нь Дорно дахины бусад орнуудад гарсан хөдөлгөөнүүдийн адил оросын анхны хувьсгалын дараа, түүний нөлөөгөөр улам өргөжин гүнзгийрч ангийн улам тод шинж чанартай болж янз бүрийн хэлбэр олж авч билээ. Манжийн эсрэг монголын ард түмний энэхүү хөдөлгөөн XX зууны эхээр мөн империализмын ч эсрэг чиглэсэн байна.

Монгол орон манж нарт XVII зууны үед байлдан дагуулагдсанаас хойш улсынхаа тусгаар тогтнолыг алдсан билээ.

Ер нь Монголын нэг адил Хятад ч гэсэн манжийн ноёрхолд нэг зэрэг шахам орсон юм. МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал энэ тухай бичихдээ, «XVII зууны үед Монгол, Хятад хоёр нэг адил хувь заяа эдлэв. Энэ хоёр орон манжийн байлдан дагуулагчдад эзлэгдсэн билээ... Хятадын хөдөлмөрчдийн адил Монголын ардууд, тэр үеийн Хятад, монголын нийгэм улс төрийн амьдралд оршин байсан муу муухай, харгис хэрцгий бүхнийг илэрхийлсэн Манж Чин улсыг гүнээ үзэн ядаж байжээ»⁴ гэж тэмдэглэсэн байна.

Манжийн эзэн хаад анхандаа Монгол орныг өөрийнхөө холбоотон гэж үзэж түүний үржил шимт газрыг зөвхөн хааны сүргийн бэлчээр болгон ашиглаж, Монгол руу хэн боловч хятад иргэдийг нүүн очихыг хатуу цаазалсан билээ. Энэ нь хууль цаазаар бататгагдсан нь Хэсэ и Тогтобуха түлэрги Монго, Хойсэ аймаг и ван гүн сэ и илэтүн улабун» (Зарлигаар тогтоосон гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шаштир) (1779) зэрэг манжийн хааны зарчмуудаас тодорхой харагдана.

Энэ баримт бичгээс үзвэл Манжийн эзэн хаад анхнаасаа Монголыг нэг бүхэл бүтэн орон гэж үзэж «Гадаад Монгол» хэмээх томъёо хэрэглэж байсан нь хэрэг дээрээ ч түүх бодит байдлын үүднээс үнэн зүйл мөн болохыг тэмдэглэвэл зохино.

Манжийн эзэн хаад Монгол орныг гадаад ертөнцөөс ялангуяа айл зэргэлдээ Орос орноос хөндий тасархай барьж байхыг хичнээн ээрэвч тэр нь нуран унасан билээ. Энэ мэт оролдлого нь империализм тэр үеийн олон улсын амьдралыг интернационалжуулж байсантай харшилснаас гадна, мөн монгол, оросын ард түмэн харилцан бие биеэ ойлголцон, харилцан найрамдалтай оршин суухад чиглэсэн уламжлалт хүсэл эрмэлзлэлтэй үл тохирсон тул тухайн үеийн дэлхий дахины хөгжлийн бодит жамаас гажсан хэрэг байлаа.

Олон улсын империализм өргөн уудам газар нутагтай, байгалийн баялаг үлэмж, бас Азийн төвд стратегийн чухал байр суурь бүхий Монгол орныг гартаа оруулах бодлого явуулж харин аль гүрэн хэрхэн ямар аргаар үүнээ гүйцэтгэхээ дор бүрэн боловсруулж байжээ.

Монголд ноёрхлоо тогтоохын төлөө голлон өрсөлдөгч нь хаант Орос, Япон хоёр байсан ажээ, Орос-Японы 1907, 1910, 1912 оны нууц гэрээгээр

³Ш. Сандаг. Некоторые аспекты влияния русской революции 1905—1907 гг. на политические события в Монголии—(«Революция 1905—1907 гг. в России и ее всемирно историческое значение») (Материалы научной конференции института марксизма-ленинизма при ЦК КПСС, Академий ЦК КПСС, Высшей партийной-школы при ЦК КПСС с участием ученых-марксистов зарубежных стран). М., 1976. с. 322—323.

⁴Ю. Цэдэнбал, Өгүүлэл. хэлсэн үгийн эмхтгэл. Боть 2, (оросоор) М., 1962: 76 дугаар тал.

Монголыг тус тусын «нөлөөний хүрээнд» хоёр хувааж Халх Монголд хаант Орос, Өвөр Монголд Япон ноёрхлоо тогтоохоор сэм хэлэлцэн тохирсон ажээ. Олон улсын капитал XIX зууны хоёрдугаар хагасаас эхлэн манжийн эзэнт гүрэнд нэвтэрч улмаар Монголыг хамрав.

Ийнхүү империализмын үед Монгол орон Алс Дорно дахь империалист хурц зөрчлийн нэг талбар болон хувирсан байна.

Манжийн эрх баригчид ийм нөхцөл байдалд Монголыг гадаад ертөнцөөс тасархай битүү бөглүү барьж байх санаархал XX зууны эхээр нэгэнт ирээдүйгүй болж ирснийг харгалзаж, мөн манж гүрний дотор улам хүчтэй болж байсан газрын эзэд, хөрөнгөтөн, милитаристуудын шаардлагаар Монголын талаархи бодлогоо эрс өөрчилж Монголд хятад иргэдийг нүүлгэн суурьшуулах явдлыг элдвээр хөхүүлэн дэмжих болжээ. Халх Монголд нүүлгэх иргэдийн хэрэг эрхэлсэн товчоо Бээжинд байгуулагдаж Халхын хамаг сайн бэлчээрийг манжийн хааны санд данслан авах арга хэмжээ авч эхэллээ. Чухам энэ үеэс Монголд хятад тариачдаас эхлэн худалдаачид, мөнгө хүүлэгчид, элдэв янзын уулганч этгээдүүд олон олноороо ирцгээн оршин суух болжээ.

Энэ бол манжийн засгийн шинэ бодлого хэмээгч мөн бөгөөд Монголд ихэвчлэн Хятадын хойд мужуудаас хятад иргэд нүүлгэн суулгаж суурьшуулах замаар тус орныг цусгүй колоничлох зорилго агуулсан байна

Манжийн төр Монголын үндэсний нэгдэл, газар дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг эвдэж түүнийг тасчин хувааж захирахад ихээхэн анхаарал тавьж тус орныг Ар, Өвөр Монгол гэж ялган үзэх болж олон хошуу болгон хуваажээ.

Монголд хятадын худалдаа, мөнгө хүүлэх капитал нь империалист гүрний худалдаа-үйлдвэрийн капиталын хамт нэвтрэх болсон нь Монголд манжийн ноёрхогчдын явуулсаар ирсэн тэртэй тэргүй хүнд хүчир цөлбөн дээрэмдэх бодлогыг улам гүизгийрүүлэв. Манжийн хаанд өргөх олон төрлийн алба гувчуур, Их Хүрээн дэх манж амбаны хээл хахууль, хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдэд тавьсан өр төлбөр ард олныг ихэд чирэгдүүлэх боллоо. Хятадын мөнгө хүүлэгчид өрийн барьцаанд түүхий эдийг хамаж мал сүргийг суурь сууриар нь булаан авсаар хөрөнгөжин баяжиж жирийн ардууд эцэст малаа алдаж хохирон хоосорсоор байжээ.

Ийнхүү Монголын эдийн засаг сүйрч мал сүрэг, бэлчээр нутаг нь харийн булаан эзлэгчдийн гарт орж үйлдвэрлэх хүчний хөгжил үлэмж саатах болжээ.

Манжийн ноёрхлын үеийн Монгол оронд улс төрийн эрх мэдэл өчүүхэн ч байсангүй. Үндэсний ба нийгмийн дарлал мөлжлийн эсрэг ард олны эсэргүүцэл тэмцэл өчүүхэн ч гарвал түүнийг манж нар хайр найргүй дарж байжээ.

Гэвч монголын ард түмэн нийгэм, улс төрийн эрх мэдэлгүй байсан ч огтхон бууж өгсөнгүй, харийн манжийн колоничлолын эсрэг зэвсэг барин боссон түүхтэй юм.

Монголд XX зууны эхээр үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцэл шинээр өрнөхөд Манжийн эсрэг урьд хожид явуулсан зэвсэгт бослогын уламжлал зохих нөлөө үзүүлсэн билээ.

Манжийн эсрэг 1911-1912 оны хөдөлгөөн янз бүрийн хэлбэрээр гарч байжээ. Ардууд мал сүргээ нуухаар хэцүү бэрх газар руу одох, хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдэд тавьсан өрийн данс харыг шатааж үгүй хийх, тэдний пүүсийг дээрэмдэн эд, бараа, мал сүргийг хуваан авах, Монгол дахь манжийн колоничлолын захиргааг эсэргүүцэхээс эхлэн зэвсэг барин босох хүртэл эвлэршгүй тэмцэл хийж байжээ.

Хятад худалдаачид мөнгө, хүүлэгчдийн эсрэг Цэцэн хан аймгийн Сансрайдоржийн хошуунд гарсан хөдөлгөөн, Засагт хан аймгийн Манибазарын хошууны ард Аюушийн бослого, Дөрвөд аймгийн ард Пунцагаар толгойлуулсан тэмцэл гарснаас гадна, Их Хүрээнд манж, хятадын дарлалыг эсэргүүцэн тэмцэх явдал олшрох болжээ. Манжийн эсрэг хөдөлгөөн Өвөр Монголыг бас хамарчээ. Энд манжийн засгийн зарлигаар хятадууд дүүрч ардуудын нутаг бэлчээр, мал сүргийг булаан авч хэлмэгдүүлэх нь ердийн үзэгдэл болжээ. Жирмийн чуулганы Жалайд хошуунд манж, хятадын эсрэг лам нар тэмцэж байсан, ялангуяа мөн чуулганы Горлос хошууны ардууд Тогтох тайжаар толгойлуулж тэндэх хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн пүүсийг бут ниргэж бараа таваарыг хуваан авч өр төлбөрийн бичиг дансыг устгаж манжийн ноёрхлыг түлхэн унагаж үндэснийхээ улс гэрийг сэргээх уриаг дэвшүүлж байсан зэрэг олон баримтыг дурдаж болно.

Манжийн эсрэг нийт Монгол орныг хамарсан үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөний төв нь Халх Монгол байсан бөгөөд Их Хүрээнд 1911 оны арван нэгдүгээр сард нэг талаас хотын ядуу ардууд, лам нар, нөгөө талаас манж амбан, хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн хооронд ширүүн тэмцэл дэгдсэнээр уул хөдөлгөөн дээд цэгтээ тулсан билээ. Халх Монголоос манжийн колоничлолын захиргааг устгаж Их Хүрээний манж амбан Сандоог түшмэдийн хамт хөөн зайлуулсан билээ. Гагцхүү Ховд дахь манж сайд бууж өгөхийг татгалзсан учир төвөөс цэрэг мордуулж орон нутгийн ардуудын хамт дайран орж цус урсгасан ширүүн тулалдааны дүнд тус хотыг чөлөөлсөн билээ.

Ийнхүү Монгол дахь манжийн колоничлолын ноёрхол устгагдаж 1911 оны арван хоёрдугаар сарын 1-нд дэлхий даяар Монголын үндэсний тусгаар тогтнол сэргээн тунхаглагдсан юм. Энэхүү Тунхагт тэмдэглэсэн нь: «Эдүгээ өмнө газар манж, хятад аймаг өвөр зуурвээн самууран манжийн төрийг сөнөөхүйц хүрсэн чимээ олонт сонсдох болсон, үүнд манай монгол болвоос угтаан тусгай нэгэн улс мөн тул одоо хуучин журмаар өвсөвээн улс болон өөрийнхөө хэргийн эрхээ бусдаар эрхлүүлэхгүй, шинэ төр байгуулан тогтоохоор зөвлөн тогтсон...»⁵ гэжээ.

Монголын үндэсний төр хэдүйгээр хэмжээгүй эрхт Богд хаант улсын хэлбэрээр сэргэсэн боловч тэрхүү үйл явдал нь тус орны эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцлийн түүхэнд гарсан дэвшилтэд үзэгдэл мөн. Энэ тухай нөхөр Ю.Цэдэнбал өгүүлэхдээ, «Монголын үндэсний улс сэргэсэн нь хэдий феодал ангийн мөн чанартай ч байлаа гэсэн, тус орны түүхэнд гарсан нилээд дэвшилттэй үйл явдал мөн, учир нь ингэснээр Монгол орныг гадаад ертөнцөөс зориуд тасархай байлгаж байсан явдлыг устгаж, монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийг орос, хятадын ард түмний хувьсгалт хөдөлгөөнтэй холбох нөхцөлийг бүрэлдүүлэв»⁶ гэсэн байна.

Монголын төр нь хэмжээгүй эрхт фердалын улс-шашин төрийг хослон барьсан Богд хаант Монгол улсын хэлбэрээр сэргээн байгуулагдсан байна. VIII богд гэгээн Жибзундамба хутагт бүх Монголын хаан ширээнд сууж он тооллыг «Олноо өргөгдсөн» гэж өргөмжлөв

«1911 оны арван хоёрдугаар сарын 1-нд Монголын тусгаар тогтнолыг зарласан Тунхаг, мөн арван хоёрдугаар сарын 29-нд Богд гэгээнийг Монголын хаан ширээнд залсан ёслол энэ бүхэн Төв Азид Монголын тулгар төр сэргэн мандаж Богд хаант Монгол улс тогтносныг дэлхий дахины өмнө нэгэнт харуулав.

⁵ТТА. Ф—2, хн 1, х—10—11.

⁶Ю. Цэдэнбал, өмнө иш татсан, мөн тэнд.

Аливаа нэг ард түмэн өөрийн хувь заяаг өөрөө шийдвэрлэх эрхтэй. Чухамхүү ийм эрхийн дагуу монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөний үр дүнд 1911 онд монголын тусгаар тогтнол сэргэж дэлхий даяар зарлан тунхаглагдсан ажээ»⁷

Богд хаант Монгол улсын бүгд ерөнхийлөн захирах яамны сайд буюу ерөнхий сайдад Сайн ноён хан Намнансүрэн, гадаад явдлын яамны тэргүүн сайдад Чин ван Ханддорж, дотоод явдлын яамны сайдад Да лам Цэрэнчимид нарыг тохоон тавьж цэрэг, шүүх, сангийн яамыг тус тус байгуулж Монгол улсын сүлд туг, далбаа, тамга тэмдгийг баталжээ. Зарлигаар зарсан Монгол улсын хууль зүйлийн бичиг зохиогдлоо.

Үүнд тэмдэглэвэл зохих нь, Богд хаант Монгол улс, монгол үндэстнийхээ улс төрийн нэгдлийг хамгаалах зорилгоор өөрийн зүүн хэсэг Өвөр Монголыг засаг захиргааны хувьд хамарч, түүнийг манж, хятадын дарлалаас ангижруулахын тулд чөлөөлөх байлдаан хийж билээ. Нөгөө талаар, Өвөр Монголын бүх дөрвөн чуулган, бараг бүх хошуу сэргэн мандсан Монгол улсад дагаар орох бичиг өргөн илэрхийлж байсан ба олон өвөр монголчууд Халхад нүүн ирсэн билээ. Их Хүрээнээ ирж суусан Өвөр Монгол том ноёдуудаас Богд хаант Монгол улсын ерөнхий сайдын орлогчоос эхлэн бусад сайдуудын орлогчийн тушаалд тавигдсан нь цөөнгүй байжээ.

Ийнхүү Богд хаант Монгол улс (1911-1919) монголын газар шороон дээр тогтсон байна. Энэ томъёоны «Богд» хэмээх үг нь VIII Богд гэгээний улс гэсэн биш, шашны тэргүүн «Богд» хаан болсон тухай утга хадгалжээ. Өөрөөр хэлбэл өмнөх аль нэг богд гэгээний үед Монгол тусгаар тогтновол, мөн л Богд хаант улс болох байлаа. Богд хаант Монгол улсын хаан нь VIII Богд гэгээн Жибзүндамба болжээ. Ингэж энэ томъёог диалектикийн үүднээс үзвэл зохино.

Өгүүлж буй үед империализм дэлхий даяар нэлэнхүйд ноёрхож олон улсын харилцаанд хүчтэй нь хүчгүйгээ дарангуйлж байсан болохоор Богд хаант Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрөх нэг ч улс байсангүй, Монголын сэргэн мандсан тусгаар тогтнол тал талаас дайсагнагч хүчнүүдтэй учирлаа.

Богд хаант Монгол улс байгуулагдсаныхаа маргаашаас эхлэн хаант Орос, Хятад, АНУ болон бусад олон улсуудад харилцан найртай ёсны харилцаа байгуулж элчин сайд солилцох тухай явуулсан илгээлтэд ганц ч улс хариу ирүүлсэнгүй дарсан байна. Дундад Иргэн улсын тухайд ахул, урьд Манж нарт нэг зэрэг шахам байлдан дагуулагдсан Монгол, Хятад хоёр улс манжийн эзэнт гүрэн мөхөхөд мөн л нэгэн зэрэг тус тусдаа урьдын адил тусгаар улс болсон нь түүхэн баримт мөн билээ.

Гэтэл 1911 оны Синхайн хувьсгалаар устгагдсан Манжийн эзэнт гүрний оронд тогтсон Дундад Иргэн улсын Юан Шикай тэргүүтэй милитаристууд Монголыг хэзээ заяанаас Хятадын хэсэг мэт үзэж өнгөлзөж байсан нь эртний Күнзийн үеэс уламжлагдсан Хятад төвийн үзэл, их гүрний дээрэнгүй, жанжлах бодлогын илрэл мөн. Түүхийн үнэнийг авч үзвэл, харин Монгол орон хэзээ ч Хятадын харъяат байгаагүй, харин Хятад өөрөө Монгол гүрний ноёрхолд удтал байсныг дашрамд хэлж болно.

Хаант Оросын хувьд гэвэл, тэрээр бусад империалист гүрнүүдийн адил Монголын тусгаар тогтнолыг дэмжсэнгүй, харин ялгаатай нь зөвхөн Халх Монголыг Дундад Иргэн улсын сюзеренитет дор орших ни-

⁷Ш. Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа 1850—1919, 2 дэвтэр. Тэргүүн дэвтэр: «Монголд манжийн ноёрхлыг устгаж үндэснийхээ тусгаар тогтнолыг сэргээн тунхагласан нь» (Богд хаант Монгол улс) 1850—1911. УБ., 1971, 316—317 дугаар тал.

лээд өргөн автономит эрхтэй орон болгон тэнд өөрийн улс төр, эдийн засгийн нөлөөг ихэсгэхийг эрмэлзэж билээ. Энэ нь Хятадын милитаристуудаас Монголыг Дундад Иргэн улсын ерийн нэг муж болгон хувиргах гэсэн оролдлогыг бодвол арай нааштай алхам мөн бөгөөд Хаант Оросын тухайн үеийн худалдаа, үйлдвэрийн эздийн эрх ашиг, Алс Дорнодын бодлогод нь тохирч байжээ.

Хэдий тийм боловч, Монгол улс тэр үед аль ч улсаар хүлээн зөвшөөрөгдсөнгүй, гэлээ ч гэсэн бодитой оршин тогтнож тусгаар тогтнолоо хамгаалан биеэ даасан гадаад, дотоод бодлого явуулсаар байв.

1912 оны аравдугаар сарын 21-ний орос-монголын гэрээ хэдийгээр Монголын хувьд тэгш бус баримт бичиг мөн боловч, Богд хаант Монгол улс оршин буй баримтыг баталж улмаар том гүрэн Оростой олон улсын гэрээ хэлэлцээрийн харилцаатай болсныг харуулж өглөө.

1913 оны нэгдүгээр сарын 11-ний монгол-түвдийн гэрээ ч мөн ийм утгатай бөгөөд хэлэлцэгч хоёр тал бие биеийхээ төрийн тусгаар тогтнолыг харилцан зөвшөөрөн хүлээлцсэн байна.

Мөн түүнчилэн Богд хаант Монгол улсын гадаад явдлын яамны сайд Чин ван Ханддорж 1912—1913 онд, Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн 1913-1914 онд тус тус Петербург одож Хаант Оросоор Монгол улсынхаа тусгаар тогтнолыг зөвшөөрүүлэн хүлээлгэх бодлого явуулж байсан боловч, амжилтанд хүрсэнгүй. Гэвч эдгээр сайд нар биеэ даасан улсаа төлөөлж Петербург очсон, Оросын хаан ба бусад эрх баригчидтай уулзсан, энэ айлчлалтын тухай дэлхий дахины сонин хэвлэлд нийтэлсэн энэ бүхэн феодалын Монгол улс өөрийгөө дэлхий даяар зөвшөөрүүлэн хүлээлгэх талаар хийсэн алхмыг илтгэж байгаа баримтын хувьд ач холбогдолтой ажээ. Мөн Хүрээний засгийн газар Япон, Америкийн Нэгдсэн улсаар зөвшөөрүүлэн хүлээлгэх оролдлого хийж байжээ.

Хүрээний засгийн газар нь тус Богд хаант Монгол улсын ар хударгаар хэлэлцэж Гадаад Монголыг автономит болгож Хятадын хэсэг гэж үзсэн 1913 оны аравдугаар сарын 23-ны Орос-Хятадын тунхагийг Монгол улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцсон зүй бус баримт бичиг, хүчингүй зүйл гэж үзсэн билээ.

Империализмын үеийн тэгш бус гэрээнүүдийн нэг-1915 оны Хиагтын гурван улсын гэрээ Богд хаант Монгол улсын тусгаар тогтнолыг устгаж үндэсний нэгдлийг бусниулж газар нутгийн бүрэн бүтэн байдлыг эвдэх зорилго агуулжээ.

Гурван улсын гэрээгээр Гадаад Монголыг Дундад Иргэн улсын хэсэг бөгөөд түүний сюзеренитет дор орших автономит болгон хүчээр тулган хүлээлгэсэн билээ.

Хэдий тийм боловч, Богд хаант Монгол улс Гадаад буюу Халх Монголынхоо хүрээгээр ч болов тусгаар тогтнолоо хамгаалж үлдэх «автономийн» далбаан дор Хятадын хэсэг болохгүйг хичээн гурван улсын гэрээг хүчингүй болгохын төлөө тэмцэл хийсэн бөгөөд уул гэрээ энэ талаар эцсийн бүлэгт цааснаас хэтэрсэнгүй гэвэл болно. Учир нь нэгд, хүрээний засгийн газар уг гэрээг биелүүлэхэд элдэв саад хийж байсан, хоёрт, уул гэрээнд оролцсон нэг гол тал болох Хаант Орос нь 1917 онд аугаа их Октябрийн социалист хувьсгалаар бут ниргэгдэн Зөвлөлт засаг тогтож урьд хожид хаант засгийн байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийг цуцлан хүчингүй болгосон явдал мөн. Харин Өвөр Монголын тухайд гэвэл, гурван улсын гэрээгээр Хятадын харьяанд үлдсэн билээ.

Монголыг автономит эрхтэй болгосондоо хятадын милитаристуудын сэтгэл нь ханаагүй юм. Монголын төр улсыг баллах, түүнийг Хятадын ерийн нэг муж болгох, монголын ард түмнийг хэмжээ хязгааргүй дарлан мөлжиж дарангуйлах гэсэн тэдний алсын муу хорт бодлогыг бие-

лүүлэхээр генерал Сюй Шужень 1919 оны намар үлэмж цэрэг авч Их Хүрээг эзлэн авч Халх Монголын «автономийг» монголын эрх баригчдаар «өөрсдөөр нь сайн дураар» устгуулж Дундад Иргэн улсын харьяаны муж болгон оруулахыг хүч тулган сүрдүүлж энэ тухай зарлан тунхаглах бичиг нийтлүүлж байсан билээ.

Дээр дурдсанаас үзэхэд, Богд Хаант Монгол улсын хэлбэрээр тунхаглагдсан Монголын төрийн тусгаар тогтнол олон улсаар зөвшөөрөгдөн хүлээгдсэнгүй ч атугай, үнэн хэрэг дээрээ 1911 оноос 1919 он хүртэл оршин тогтсоор байжээ.

1919 онд хятадын милитаристууд цэргийн хүчээр Монгол орныг эзлэн түүний төр улсыг устгасан тухай зарласнаар Монгол орны хувь заяа Хятадын ашиг тусад хараахан шийдвэрлэгдсэнгүй.

Орчин үед Хятадын эрх баригчид, тэдний үзэл сурталчид, түүхчид манай БНМАУ-ыг Хятадын хэсэг мэт үзэж түүний түүхийг бүхэлд нь эрээ цээргүй мушгин гуйвуулж байгаа нөхцөлд Богд хаант Монгол улсын үеийг (1911-1919) түүхийн үүднээс шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэн зөв дүгнэх явдал улс төрийн чухал ач холбогдолтой юм.

Бээжингийн эрх баригчид, маогийн түүхчид үзэхдээ, монголын ард түмний 1911-1912 оны хөдөлгөөнийг нийт Монголыг хамраагүй гэх буюу 1911 онд Халх Монгол Хаант Оросын хатгалгаар «автономио» зарлан Хятадын харьяанд үлдсэн мэтээр аль болохоор хятадын жанжлах, булаан эзлэх бодлогонд ашигтайгаар манай Монголын энэ үеийн түүхийг мушгин гуйвуулж байгаа нь дээр дурдсанаас үзэхэд түүхийн бодит байдалтай тохирохгүй байна.

1911-1919 оныг Халх Монгол Хятадын харьяаны автономи байсан юм гэж үзэх нь шинжлэх ухаан, улс төрийн үүднээс ноцтой алдаа болох бөгөөд ийм учраас маогийн түүхчид ингэж хэлэх дуртай байдаг байна.

Ингэж Монголд манжийн хоёр зуу илүү жилийн колоничлолын ноёрхол устгагдаж тус орны тусгаар тогтнол тунхаглагдсан явдал монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөний нэг чухал үе шат, том амжилт мөн бөгөөд Монголын түүхнээ гарсан дэвшилтэт үйл явдал болжээ.

Богд хаант Монгол улс бол феодалын хэмжээгүй эрхт хаант улс мөн тул, нийгмийн дарлал хэвээр үлдсэн ажээ. Хэдийгээр манжийн феодалуудад залгуулах алба гувчуур, тэдний дарангуйлал устгагдсан боловч, дотоодын шар хар феодалууд урьдын адил ардуудыг мөлжсөөр байжээ. Үндэсний дарлалын нэг ноцтой хэлбэр-манжийн ноёрхол эцэс болсон боловч, түүний бусад хэлбэрүүд мөн л хэвээр үлдсэн юм. Энэ нь хятадын худалдаа, мөнгө хүүлэх капитал, империалист орнуудын худалдаа-санхүү-үйлдвэрийн капиталын дарлал мөлжлөг мөн. Өөрөөр хэлбэл, нийгмийн ба үндэсний дарлал хэвээр үлдэж ангийн тэмцэл хурцадсаар байжээ.

Нөгөө талаар өгүүлж буй үед Монгол оронд аугаа их Октябрийн социалист хувьсгалын нөлөөгөөр феодализм, империализмыг эсэргүүцсэн ардын хувьсгалын үр хөрөнгө үүсч байжээ. «Тэмцлийн ямар замаар замнавал, жинхэнэ эрх чөлөө, тусгаар тогтнолыг олох вэ гэдэг асуудал тэр үед монголын ард түмний өмнө амьдралаар дэвшин тавигдаж билээ»⁸

1921 онд монголын ард түмэн В. И. Лениний заалт, МАХН-ын жолоодлогоор ардын хувьсгалыг ялан мандуулж эх орныхоо жинхэнэ эрх чөлөө, тусгаар тогтнолыг байлдан олж нийгмийн ба үндэсний дарлалаас бүрэн ангижирч чадсан юм.

Энэхүү хувьсгалыг ялан мандуулахад 1911 онд Манжийн хоёр зуу гаруй жилийн колоницлолын дэглэмийг устгаж, Монголынхоо тусгаар тогтнолыг сэргээн мандуулж, түүнээ хятадын милитаризм, олон улсын империализмаас хамгаалахын төлөө 1911-1919 онд монголын ард түмний явуулсан тэмцэл улс төрийн чухал туршлага болж өгсөн байна.

ВОССТАНОВЛЕНИЕ НЕЗАВИСИМОСТИ МОНГОЛИИ И ЕГО ИСТОРИЧЕСКОЕ ЗНАЧЕНИЕ

(Резюме)

Ш. Сандаг

Статья посвящена важному событию в истории МНР, положившему конец колониальному господству Цинского Китая в Монголии и восстановлению ее государственной независимости.

Со времени покорения Монголии маньчжурскими завоевателями еще в XVII веке, Монголия, потеряв свою независимость, находилась под игом маньчжурских колонизаторов на протяжении более двухсот лет. Только после первой русской революции и под ее влиянием, в Монголии, как и в других странах Востока, все шире разворачивалась национально-освободительная борьба народов, которая приобретала разнообразные формы.

В результате успешного завершения антиманьчжурского освободительного движения аратства, 1 декабря 1911 года была обнародована декларация о восстановлении государственной независимости Монголии в форме Богдоханской монархии. В декларации не было ни слова об автономии, а ясно говорилось о восстановлении государственной независимости Монголии. Монгольский народ боролся за независимость страны и одержал, в известном смысле победу, добившись самостоятельности. Этот период 1911-1919 годов в истории Монголии можно называть периодом Богдоханской, т. е. теократической монархии.

Маоистские историки, грубо извращая историю Монголии, пытаются утверждать, что в 1911 году будто бы Внешняя Монголия объявила автономию в составе Срединной Республики. Такая интерпретация этого важного периода в истории Монголии не выдерживает критики, она отражает великодержавно-шовинистические и китаецентрические взгляды правящих кругов Пекина.

Автор, анализируя фактический материал, подвергает научно-обоснованной критике фальсификацию маоистами этого важного периода в истории борьбы монгольского народа за свободу и независимость своей страны и её национальной государственности.